

Олон Нийтийн Хэлэлцүүлгийн Төлөвлөгөө (ОНХТ)

Ухаа худаг нүүрсний уурхай ба зам
сайжруулан засварлах хөтөлбөр

*2008 оны 11дүгээр сар
Улаанбаатар хот, Монгол Улс*



АГУУЛГА

1.0	Удиртгал	3
	Зураг 1 Ухаа худаг нүүрсний уурхай ба замын байршил	4
	Зураг 2 Олон нийтийн хэлэлцүүлэгийн хамрах хүрээ – Ухаа худаг уурхай ба зам	5
2.0	Эрх зүйн зохицуулалт ба шаардлагууд	5
2.1	Нийгэм ба Байгаль орчны эрх зүйн барим бичиг	5
	2.1.1 Монгол улсад мөрдөгдөж буй Байгаль орчны хуулиуд	7
2.2	ЕСБХБ-ны Олон нийтийн үр дүнтэй хэлэлцүүлгийн шаардлагууд	8
3.0	Олон нийтийн хэлэлцүүлгийн бэлтгэл үйл ажиллагаа	8
3.1	Сонирхогч талуудыг судлан тодруулах, дүн шинжилгээ	9
	Хүснэгт 1: Ухаа худаг уурхайн орчмын өрхүүдийн судалгаа	9
4.0	Сонирхогч талуудыг татан оролцуулах үйл ажиллагаа	10
5.0	ОНХТ-ны хураангуй – үйл ажиллагааны төлөвлөгөө	12
	5.1 Хөтөлбөр: Олон нийтийн хэлэлцүүлгийн ажлын төлөвлөгөө	15
6.0	Санал хүсэлт хүлээж авах, шийдвэрлэх арга зам	20
7.0	Тайлагнах	21
	7.1 Мэдээлэл авах, холбоо барих хаяг	21
	Байршлын зураг:	23
8.0	Эх сурвалжийн жагсаалт	23
	Хавсралт 1: Нээлттэй өдөрлөгийн хөтөлбөр	24
	Хавсралт 2: Уул уурхайн мэдээлэл – 2008.11.10	25
	Хавсралт 3: Санал хүсэлтийн хуудас	26
	Хавсралт 4: Санал хүсэлт барагдуулах үйл ажиллагаа	27

1.0 Удиртгал

Энержи Ресурс ХХК нь Ухаа худаг (УХ)-н нүүрсний орд газрын ашиглалтын лицензийг эзэмшдэг бөгөөд уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулж, Гашуун сухайт хилийн боомт хүртэлх нүүрс тээврийн замын сайжруулан засварлаж БНХАУ-д нүүрс экспорлох зорилт тавин ажиллаж байна. Монголчуудын 100 хувийн хөрөнгө оруулалттай Энержи Ресурс ХХК-ний зүгээс Олон нийтийн хэлэлцүүлгийн төлөвлөгөө (ОНХТ)-г дэлхийн жишигт хүрсэн хэлбэрээр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Ухаа худаг нүүрсний уурхай нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан овоо багийн газар нутагт байрладаг. Тухайн уурхай нь Таван толгойн нүүрсний орд газраас ойролцоогоор 4км, Даланзадгад хотоос 90-д км, Монгол Улс ба БНХАУ-н хилээс 200-д км, Улаанбаатар хотоос 540-д км-г оршино. Мөн түүнчлэн, Ухаа худаг нүүрсний уурхайгаас Айвенхоу Майнз Монголия Инк ХХК-н хэрэгжүүлж буй Оюу толгойн зэс-алтны орд хүртэл 150-д км зайтай.

Сайжруулан засварлахаар төлөвлөж буй уурхайгаас Монгол улсын өмнөд хил хүртэл нүүрс тээвэрлэх одоогийн шороон зам нь Баян Овоо, Ханбогд сумын нутаг дэвсгэрийг дайран өнгөрнө. Уурхайн төслийн байршил болон төлөвлөж буй замын чиглэлийг дараахь зурагт харуулав.


Энержи Ресурс ХХК нь Ухаа худаг нүүрсний уурхайн үйл ажиллагааны хүрээнд харилцан уялдаатай хоёр төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

- **Ухаа худаг уурхай** нь 2009 оноос эхлэн автосамосвал-экскаваторын хослолоор жилдээ ойролцоогоор 1.0 сая тонн түүхий коксжих нүүрс олборлон тээвэрлэнэ. Олборлосон нүүрсийг боловсруулахгүйгээр БНХАУ-н зах зээлд шууд нийлүүлнэ. Олборлолтын үйл ажиллагаа эхэлснээс 12-18 сарын дараа Нүүрс угаах үйлдвэрийн эхний ээлж ашиглалтанд орсноор баяжуулсан нүүрс экспортлох боломж бүрдэнэ. Нүүрс угаах үйлдвэр нь жилд дундажаар 2.5 сая тонн түүхий нүүрс хүлээн авч 1.75 сая тонн баяжуулсан коксжих нүүрс гаргах хүчин чадалтай байна. Уурхайн олборлолтын төслийн хүчин чадал эзэмших хугацааг ойролцоогоор 6 жил гэж тооцоолж байгаа бөгөөд Энержи Ресурс ХХК нь энэ хугацаанд уул уурхайн мэргэжлийн гүйцэтгэгч компанитай уурхайн олборлолт ба баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаан дээр хамтран ажиллана. Нүүрс боловсруулах үйлдвэр барих хугацаатай уялдуулан эхний жилүүдэд сайн чанарын коксжих нүүрстэй 3 ба 4 дүгээр давхаргыг ашиглахаар төлөвлөж байна.
- **Зам сайжруулан засварлах** төсөл нь БНХАУ-н хил хүртэл тавигдсан одоо ажиллаж байгаа нүүрс тээврийн замыг (бага Таван Толгойн уурхайгаас жилдээ 2.5 сая тонн нүүрс тээвэрлэдэг) сайжруулан засварлах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэгдэж байна. Тухайн төслийн хүрээнд одоо байгаа замыг буталсан чулуу шаврын зуурмагаар хучилт хийж нягтруулан сайжруулах ажлыг гүйцэтгэж, урсгал засвар, арчилгааны арга хэмээний төлөвлөгөө гарган ажилласнаар замын осол аваарыг багасгах, тоосжилтыг бууруулах нөхцөл бүрдэнэ. Одоо байгаа зам нь


байгаль орчинд их хэмжээний сөрөг нөлөө үзүүлж байгаа бөгөөд энэхүү нөлөөллийг бууруулахад уг төслийн гол ач холбогдол оршино.

Энэхүү баримт бичигт дурдагдаж буй ОНХТ-ний арга хэмжээнүүд нь зөвхөн уурхай ба замын төслийн эхний үе шатанд хэрэгжинэ. Уурхай урт хугацааны үйл ажиллагаанд зориулж ОНХТ тусад нь боловсруулах болно.

Зураг 1 Ухаа худаг нүүрсний уурхай ба замын байршил



Зураг 2 Олон нийтийн хэлэлцүүлгийн хамрах хүрээ – Ухаа худаг уурхай ба зам



Энержи Ресурс компани нь нүүрсний уурхай болон замын төслүүдэд Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (ЕСБХБ)-наас санхүүгийн дэмжлэг үзүүлэх хүсэлт гаргасан. Банкны Зээлдэгчид тавих шаардлагыг хангах үүднээс тухайн төслүүдэд Байгаль орчин ба нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээг 2008 оны 10 дугаар сард хийсэн бөгөөд энэхүү ОНХТ нь орон нутгийн сонирхогч талууд болон нөлөөллийн хүрээний иргэдтэй харилцан мэдээлэл солилцох, түгээх үйл ажиллагааг үр дүнтэй хэлэлцүүлэг хэлбэрээр зохион байгуулах үндэслэл болж байна.

ЕСБХБ-ны шаардлага болон олон улсын шилдэг арга барилын хүрээнд тухайн төслийн ОНХТ-ний баримт бичгийг боловсруулсан болно. Энэхүү ОНХТ-ыг боловсруулахдаа ЕСБХБ нь 2003 оны Байгаль орчны бодлого болон 2008 оны Гүйцэтгэлийн шаардлагын баримт бичгүүдийн нөхцлийг хэрэгжүүлэхэд онцлон анхаарч ажилласан.

2.0 Эрх зүйн зохицуулалт ба шаардлагууд

2.1 Нийгэм ба Байгаль орчны эрх зүйн баримт бичгүүд

Монгол улс нь Байгаль орчны чиглэлийн сайн боловсруулсан багц хуулиудтай бөгөөд аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаандаа тухайн эрх зүйн баримт бичгүүдийг мөрдөн ажиллаж

байна. Уурхай ба замын төслийн байгаль орчин ба нийгмийн үнэлгээг боловсруулахдаа холбогдох эрх зүйн баримт бичгүүдийг мөрдлөгө болгон ажилласан. Байгаль орчны эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтийн дүн шинжилгээг Энержи Ресурс компани ба ЕСБХБ-ны цахим хуудсанд байршуулсан уурхай ба замын Байгаль орчин ба нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланд тусгасан болно.

Нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ, хэлэлцүүлэгийн хувьд авч үзвэл олон нийтийн хэлэлцүүлэг, мэдээлэл солилцооны чиглэлээр тодорхойлон заасан эрх зүйн баримт бичиг одоогоор Монгол улсад байхгүй байна. Гэхдээ, Байгаль орчин хамгаалах тухай (1995) болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай (1998) хуулиудад Монгол улсын иргэн хэрэгжүүлж буй төслийн тухай мэдээлэл авах, байгаль орчин хамгаалах үйл ажиллагаанд оролцох эрхтэй гэж тусгасан байдаг. Олон нийтийн хэлэлцүүлэгийн хамгийн наад захын стандартыг тодорхойлсон эрх зүйн зохицуулалтын баримт бичиг хангалтгүйгээс шалтгаалан тухайн төслийн үйл ажиллагаанд орон нутаг ба олон улсын хамгийн сайн стандартуудыг хэрэгжүүлэхийг зорьж ЕСБХБ-аас 2003 онд боловсруулан гаргасан Байгаль орчны бодлогын баримт бичигт тусгасан үр дүнтэй хэлэлцүүлэгийн үзэл санааг мөрдлөг болгон Сонирхогч талуудын оролцооны гүйцэтгэлийн шаардлагуудыг (2008) баримтлаж байна.

Одоогийн байдлаар, байгаль орчны менежмент болон байгаль орчны баримт бичгийн баталгаажуулалтын процедурыг тусгасан Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 32 хууль, дүрэм байгааг дараахь хүснэгтэд үзүүлсэн болно.

Эдгээр хууль, дүрмүүд нь компанийн үйл ажиллагаанд шууд нөлөөлдөггүй боловч орон нутгийн хүмүүст уул уурхайгаас үзүүлэх нөлөөллөөс хамааран эдгээр хууль, дүрмүүдийн үйлчлэх хүрээ харилцан адилгүй байдаг. Шилжүүлэн суурьшуулах, нөхөн олговор олгох, хэлэлцүүлэг явуулах зэрэг дээр тодорхойлон заасан эрх зүйн орчин хангалтгүйгээс шалтгаалан олон улсын дэвшилтэт арга барил болон ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлагын баримт бичгийг тухайн ОНХТ-нд авч хэрэглэсэн.

2.1.1 Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Байгаль орчны хуулиуд

Нөөцийн төрлүүд	Хууль, батлагдсан он
Газрын нөөц	Монгол улсын хууль Газрын тухай, 1994, шинэчилэн найруулсан 2002 Монгол улсын хууль Газрын төлбөрийн тухай, 1997, шинэчилсэн 2002 Монгол улсын хууль Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай, 2002 Монгол улсын хууль Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, 2002 Монгол улсын хууль Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай, 1999, шинэчилсэн 2005
Ашигт малтмал, газрын тос, хий	Монгол улсын хууль Газрын хэвлийн тухай, 1988, шинэчилсэн 1994 Монгол улсын хууль Ашигт малтмалын тухай, 1997, шинэчилсэн 2006 Монгол улсын хууль Газрын тосны тухай, 1991, шинэчилсэн 1999
Ойн нөөц	Монгол улсын хууль Ойн тухай, 1995, шинэчилсэн 2007 Монгол улсын хууль Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн тухай, 1995 Монгол улсын хууль Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай, 1996
Усны нөөц	Монгол улсын хууль Усын тухай, 1995, шинэчилсэн 2004 Монгол улсын хууль Ус, рашаан ашигласны төлбөрийн тухай, 1995 Монгол улсын хууль Рашаан усны тухай, 2003
Ургамлын нөөц	Монгол улсын хууль Ургамал хамгааллын тухай, 1996 Монгол улсын хууль Байгалийн ургамлын тухай, 1995 Монгол улсын хууль Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай, 1995
Зэрлэг амьтад	Монгол улсын хууль Ан агнуурын тухай, 2000 Монгол улсын хууль Амьтаны аймгийн тухай, 2000 Монгол улсын хууль Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хууль, 1995
Үндэсний парк	Монгол улсын хууль Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, 1996 Монгол улсын хууль Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай, 1997
Авран хамгаалах хууль	Монгол улсын хууль Байгаль орчныг хамгаалах тухай, 1995, шинэчилсэн 2005 Монгол улсын хууль Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, 1998, шинэчилсэн 2001 Монгол улсын хууль Агаарын тухай, 1995
Бусад	Монгол улсын хууль Химийн хорт бодисоос хамгаалах тухай, 1995 шинэчилсэн 2005 Монгол улсын хууль Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай хууль Монгол улсын хууль Ховордсон амьтан, ургамал тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль Монгол улсын хууль Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай Монгол улсын хууль Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль Монгол улсын хууль Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээний тухай хууль, 2000

Эх сурвалж: http://www.pmis.gov.mn/parl_mon.htm, EcoTrade LLC, Улаанбаатар, Монгол улс.

2.2 ЕСБХБ-ны Олон нийтийн үр дүнтэй хэлэлцүүлгийн шаардлагууд

Энержи Ресурс компани нь ЕСБХБ-н дараахь үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлж байна. Үүнд:

“ , сонирхогч талуудын оролцоог хангах нь нийгмийн хариуцлагатай сайн бизнесийн арга барилын үндсэн хэсэг бөгөөд төслийн чанарыг сайжруулах арга зам мөн. Чухамдаа, олон нийтийн идэвхитэй, үр ашигтай оролцоо нь төслийн хүрээнд хамрагсдын нөлөөлөл ба эрсдэлийн менежментийг амжилттай хэрэгжүүлэх төв болох төдийгүй нийгмийн ашиг орлого дээшлэх үндэс болдог.” (ЕСБХБ, пп76)

Энэхүү ОНХТ нь уурхайн хөгжил, зам сайжруулах төслүүдийн хүрээнд оршиж буй мэдээлэл солилцоо, сонирхогч талуудын оролцооны хөтөлбөрийг сайжруулах механизмыг бүрдүүлж байна. Энэ нь дараахь зарчим дээр үндэслэгдэнэ. Үүнд:

- 1) Орон нутгийн иргэд төслийн талаар мэдээлэл хүртэх эрхтэй;
- 2) Төсөл бодлого, төлөвлөлтөө ил тодоор илэрхийлэх зарчмыг агуулсан үр дүнтэй хэлэлцүүлгийг албадан шахалтгүй, шударгаар явуулах;
- 3) Иргэдийн санал хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх механизмыг бий болгох;
- 4) Төсөл хэрэгжих нийт хугацааны туршид сонирхогч талуудын оролцоог хангах үйл ажиллагааг тогтмол явуулах;

Эдгээр зарчимуудыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд уурхай ба замын төслүүдийн хүрээнд төслийн мэдээллийг орон нутгийн иргэдэд түгээх хүртээмжтэй, тохиромжтой арга замуудыг сонгон олох шаардлага гарч байна. Мэдээлэл түгээх арга зам нь брошюр, радио сурталчилгаа, мэдээллийн товхимол зэргийг сум, багийн засаг дарга нараар дамжуулан нутгийн иргэдэд тараах, сумын захиргаан дээр мэдээллийн самбар ажиллуулах хэлбэртэй байна. Олон нийтийг хамарсан наадам, морины уралдаан зэрэг тэмдэглэлт үйл явдлын үер Нээлттэй өдөрлөг зохион байгуулах нь мэдээллийг өргөн цар хүрээтэй түгээх шинэлэг механизм байж болох юм. Үүнийг дараагийн бүлэгт тодорхой авч үзэх болно.

ЕСБХБ-ны ангилалаар уурхайн төсөл нь ‘А’ зэрэглэлд, зам сайжруулах төсөл нь ‘В’ зэрэглэлд хамаарч байгаа учраас төслийн зүгээс нөлөөллийн бүлэг рүү чиглэсэн хэлэлцүүлэгийг тогтмол явуулахаар төлөвлөж байна.

3.0 Олон нийтийн хэлэлцүүлгийн бэлтгэл үйл ажиллагаа

Төслийн бэлтгэл ажлын үед сонирхогч талын оролцоо хангалтгүй байсан бөгөөд ялангуяа сонирхогч талыг тодруулах, дүн шинжилгээ хийх үйл ажиллагаа хийгдээгүй нь нийгэм ба байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний судалгааны ажлын зорилгыг тодорхойлох явцад тодорхой болсон. Компани нь сум, орон нутгийн засаг захиргааны түвшинд

идэвхитэй, үр ашигтай хамтран ажиллаж байсан боловч тухайн төслийн нөлөөллийн хүрээнд хамрагдагсад болон малчидтай харилцах, тэдний оролцоог хангах тал дээр шилдэг арга барилыг нэвтрүүлэх чиглэлээр хангалтгүй ажилласан байна.

Үүнийг арилгахын тулд энэхүү ОНХТ-р орон нутгийн малчид, нөлөөллийн бүлэг рүү чиглэсэн мэдээллийн компани ажил даруй зохион байгуулах стратегийг боловсруулж байна. Энэ арга хэмжээний хүрээнд зорилтот бүлэг, сонирхогч талуудыг оролцуулсан уулзалтуудыг зохион байгуулахаар төлөвлөж байна. Энэ нь 2008 оны 10 дугаар сард эхэлсэн сонирхогч талуудыг тодруулах үйл ажиллагааны үргэлжлэл болно.

3.1 Сонирхогч талуудыг судлан тодруулах, дүн шинжилгээ хийх процесс

ОНХТ-г боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд сонирхогч талуудыг тодруулах судалгаа хийгдсэн. Төслийн Нийгмийн нөлөөллийн үнэлгээг хийх явцад энэхүү судалгааг Байгаль орчны нөөцийн менежмент (БОНМ)-н багийн ажилтан доктор Калев Вол гүйцэтгэсэн болно. Үнэлгээг Бодлого судлалын төвийн хийсэн судалгааны ажил, доктор Волын сонирхогч талуудтай хийсэн чөлөөт ярилцлага, судалгаан дээр үндэслэн боловсруулсан.

Энержи Ресурс компани нь төслийн нөлөөллийн хүрээний сонирхогч талуудтай харилцан ярилцлага явуулах, нийгэм эдийн засгийн дүн шинжилгээг хийлгэхээр Улаанбаатар хотноо байрлан үйл ажилагаагаа явуулдаг Төрийн бус байгууллага Бодлого судлалын төв (БСТ)-тэй гэрээ байгуулан ажилласан. 10 сарын 5-12-ны хооронд БСТ-н 9 судлаачдын бүрэлдэхүүнтэй баг Өмнөговь аймгийн Цогтцэций, Баян Овоо, Ханбогд сумын 8 багт ажиллан 336 өрхөөр орж нийтдээ 380 хүнээс ярилцлага авсан байна. Ярилцлагын хураангуйг дараахь хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1: Ухаа худаг уурхайн орчим амьдрагч өрхүүдийн судалгаа

Сум	Өрхүүд					
	Малчид	Малтай*	Малгүй *	Ажилгүй*	Төрийн албан хаагчид*	Нийт
Цогтцэций	185	20	27	12	32	276
Баян Овоо	23					22
Ханбогд	37					38
Нийт	245	20	31	18	33	336

Тэмдэглэл: * -Цогтцэций сумын төвд амьдрагсад

GPS багажийн тусламжтайгаар судалгаанд хамрагдсан өрхүүдийн байршлыг тодорхойлон баримтжуулсан болно. Судалгаанд хамрагдсан өрхүүдийн байршлыг Зураг 2-г тусгасан бөгөөд уурхайн үйл ажиллагааны нөлөөллийн бүлгийг ногоон пирамидээр, цэнхэр ягаан өнгөөр замын дагуух өрхүүдийг тэмдэглэсэн болно.

Гүнзгийрүүлсэн судалгааг доктор Калев Вол 10 дугаар сарын 18-наас 11 дүгээр сарын 3-ны хооронд Монгол улсад байх хугацаандаа гүйцэтгэсэн. Энэ ажлын хүрээнд 10 дугаар сарын 21-25-ны хооронд Ухаа худаг уурхайд очиж гол сонирхогч талууд болох орон нутгийн засаг дарга нар, малчидтай уулзаж ярилцан судалгаа хийсэн болно.

Судалгааны үр дүнд төслийн нөлөөллийн хүрээнд хамрагдах хэсгүүдыг тодорхойлов. Үүнд:

- 1) Замын трассаас 15 км-ийн бүсэд малаа бэлчээж буй малчид (нийт 450 ам бүлтэй 100 өрх айл)
- 2) Уурхайн талбайгаас 50 км-н бүсэд малаа маллаж буй малчид (нийт 45 ам бүлтэй 10 өрх айл)
- 3) Уурхайн кемпийн ойр амьдарч буй Цогцэций сумын иргэд
- 4) Замын ойр амьдарч буй Баян Овоо сумын Сийрэт багийн иргэд
- 5) Зам барилгын ажилчдын кемп байрлуулахаар төлөвлөж буй газрын ойр орчмын малчин иргэд (3 сумын хэмжээнд)
- 6) Компанийн ажилчид ба ханган нийлүүлэгчид
- 7) Орон нутгийн төрийн байгууллагын эрх мэдэлтнүүд ялангуяа зөвшөөрөл, хүний нөөц, эрүүл мэндийн чиглэлийн ажил эрхэлдэг төрийн албан хаагчид
- 8) Өмнөговь аймаг болон Улаанбаатар хотын иргэний нийгмийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд
- 9) Шинжлэх ухаан, судалгааны байгууллагууд, ялангуяа байгаль орчин болон Монгол улсын хөгжилд үзүүлэх уул уурхайн нөлөөллийн судалгааны чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг байгууллагууд
- 10) Бусад сонирхлын бүлгүүд

Энэхүү хэлэлцүүлгийг зохион байгуулснаар Ухаа худаг төслийн хүрээнд хамрагдах эрсдлийн бүлэг, эсвэл зам сайжруулах болон уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн хувь хүнийг тодруулах боломж бүрдэнэ. Энэхүү үйл ажиллагааны нэгэн хэсэг нь хийсвэр нөлөөллөөс бодит нөлөөллийг салган авч үзэн олон нийтийн дунд тархсан сөрөг нөлөөллийн тухай хийсвэр ойлголтыг арилгахын тулд мэдээлэл түгээх замаар тайлбарлан таниулах үйл ажиллагаа явуулахад оршиж байна. Нийгэм ба байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний явцад ярилцлаганд оролцсон нөлөөллийн бүсэд амьдарч буй иргэдтэй холбоо тогтоож, санал бодлоо солилцоход сонирхогч талуудын оролцоог хангах төлөвлөгөө чиглэгдэнэ.

4.0 Сонирхогч талуудыг татан оролцуулах үйл ажиллагаа

Төсөлд сонирхогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөөний дагуу Орон нутгийн харилцааны ажилтны зүгээс нөлөөллийн бүлэг болон сонирхогч талуудтай тогтмол уулзаж, хэлэлцүүлэг хийхэд голлох үүрэг хүлээнэ.

Энэ үүрэгт ажилд хамгийн эрсдэлтэй бүлгүүдийн гэр орноор тогтмол очиж уулзах, говь нутагт мэдээлэл дамжуулагч гүүр болдог багийн засаг даргатай сар бүр уулзах зэрэг үйл ажиллагаа орно.

Мөн үүнээс гадна, Ухаа худаг төслийн зүгээс олон нийтийн уулзалт, хэлэлцүүлгийн багц ажлуудыг хөдөө орон нутаг болон төв суурин газруудад зохион байгуулах төлөвлөгөө гарган сонирхогч талуудаас санал хүсэлт хүлээн авах эргэх холбоог бий болгож байна. Уулзалт, хэлэлцүүлгийн ирцийг дээшлүүлэхийн тулд олон талын арга хэмжээ авч явуулах боломжтой бөгөөд үүний нэг жишээ нь сонирхогч талуудын идэвхитэй оролцоог хангах үүднээс тэдэнд унаагаар үйлчлэх, үнэгүй байршуулах зэрэг үйл ажиллагааг төслийн зүгээс явуулж болно.

Олон нийтийн уулзалтууд нь төслийн явцын мэдээллийг түгээхэд чиглэгдэнэ. Саяхан гэхэд Ухаа худаг төслийн ирээдүйн үйл ажиллагааны талаар зөвхөн сумын засаг даргатай харилцан ярилцаж байсан бол одоо төслийн зүгээс нөлөөллийн бүлгүүдтэй ирээдүйн төлөвлөлтийн талаар санал солилцох болно. Үйл ажиллагааны сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах, эсвэл зохион байгуулалтын арга хэмжээ төлөвлөх зэрэг хувилбаруудыг Орон нутгийн харилцааны ажилтан төслийн менежментийн багт санал болгох бөгөөд хариу арга хэмжээний хувилбаруудыг судлах үйл ажиллагаа явагдана.

Төслийн үйл ажиллагааны талаар санал хүсэлт хүлээн авах ажиллагаа нь ЕСБХБ-ны үр дүнтэй хэлэлцүүлгийн шаардлагыг (ЕСБХБ, пп 79) хангасан байна. Энэ нь:

- 1) Шийдвэр гаргахаас өмнө хувилбарууд нээлттэй байх үед тохиромжтой, холбогдох баримт бичгүүд, төлөвлөгөөний төслийн хангалттай мэдээллийг түгээхэд чиглэгдэнэ;
- 2) Байгаль орчин ба нийгмийн үнэлгээний үйл ажиллагааны төслийг юуны өмнө боловсруулна;
- 3) Нийгэм ба байгаль орчны эрсдэл, сөрөг нөлөөлөл, төлөвлөсөн арга хэмжээ болон эдгээрийг гүйцэтгэх үйл ажиллагаанд анхаарна;
- 4) Асуудал, нөлөөлөл, боломжуудыг өрнөлтийн нөхцөл байдал дээр үндэслэн зохион байгуулахад оршино.

Эдгээр стандартуудыг биелүүлэх ажлын хүрээнд уурхай ба зам сайжруулах төслийн зүгээс зохион байгуулсан хэлэлцүүлэгийн үр дүнг сонирхогч талуудад тайлагнаж төслийн үйл ажиллагааг яагаад явуулсан тухай тайлбарлана. Энэ мэдээлэл нь олон нийтэд нээлттэй байх ба ЕСБХБ-д хүргэгдэх үе шатны ажлын тайланд орж улмаар Энержи Ресурс компанийн жилийн ажлын тайланд орно.

Олон нийтийн хэлэлцүүлэгийн төлөвлөгөөний аргачлалыг дараахь хүснэгтэд үзүүлсэн бөгөөд энэ нь сонирхогч бүлэг бүрд чиглэсэн харилцааны хүртээмжтэй, тохиромжтой хэрэгсэл юм.

Хамрагдах хэсэг	Татан оролцуулах арга ажиллагаа
Уурхай ба замын үйл ажиллагааны нөлөөллийн бүсийн малчид	* Орон нутгийн харилцааны ажилтантай шууд харилцах * Сурталчилгаа, соёлын арга хэмжээнүүдтэй нээлттэй өдөрлөгүүд * Брошюр тараах замаар шинэ мэдээ мэдээлэл тогтмол түгээх
Уурхай ба замын ойр байрлах сумын төвийн оршин суугчид	*Сумын соёлын төвүүд, засаг даргын тамгын газар байршуулсан мэдээллийн самбараар мэдээлэл, тараах материал түгээх * Орон нутгийн харилцааны ажилтантай уулзалт хийх
Малчид ба сумын оршин суугчид	* Олон нийтийн хэлэлцүүлэг, нээлттэй өдөрлөгт урих * Брошюр, олон нийтийн радио нэвтрүүлэг гэх мэт
Ажилчид, гэрээт ажилчид, ханган нийлүүлэгчид	* Компанийн ажилчид, албан хаагчид, ханган нийлүүлэгчдийн дунд явуулах сургалт, зааварчилгаанууд, санал хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх механизм
Орон нутгийн эрх мэдэлтнүүд, зөвшөөрөл олгогч албан хаагчид	* Орон нутгийн харилцааны ажилтантай шууд харилцах * Нээлттэй өдөрлөг, уурхайн талбайд урьж авчрах
Өмнөговь аймгийн иргэний нийгмийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд	* Компанийн тайлан, мэдээлэл, брошюр авах боломжийг хангах * ОНХА болон УБ хотын байрладаг захирлуудын оролцоог хангах
Шинжлэх ухаан, судалгааны байгууллагууд	* Компанийн тайлан, мэдээлэл, брошюр авах боломжийг хангах * Энержи Ресурс компанийн олон нийтийн үйл ажиллагааны оролцоог дээшлүүлэх
Бусад сонирхогч бүлгүүд	* Компанийн тайлангууд, цахим хуудас ажиллуулах ба мэдээллийг тогтмол шинэчлэх, санал асуулгад хариулах, холбоо барих хаяг тодорхой байх

5.0 ОНХТ-ны хураангуй – Үйл ажиллагааны төлөвлөгөө


Төслийн хүрээнд үр дүнтэй хэлэлцүүлэг зохион байгуулах зорилгоор Ухаа худаг уурхай болон замын төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараахь олон нийтийн хэлэлцүүлгийн аргачлалыг нэвтрүүлнэ. Холбогдох хүний мэдээллийг энэ баримт бичгийн 7.1 бүлэгт оруулсан.

1. Ухаа худаг төслийн үйл ажиллагаанд хамрагдах хүрээлэл буюу Цогтцэций, Баян Овоо, Ханбогд суманд зохион байгуулах Олон

нийтийн хэлэлцүүлэг уулзалтын арга хэмжээнүүд: сум тус бүрийн сургуулийн биеийн тамирын зал, соёлын төвүүдэд тухайн арга хэмжээг 2008 оны 12 дугаар сард зохион байгуулна. Арга хэмжээний зарыг том хэмжээгээр хэвлэн сумын төв болон багийн төвд байрлуулах бөгөөд уулзалтын хөтөлбөрийг зорилтот оролцогчдод уулзалт эхлэхээс 3 долоо хоногийн өмнө хүргүүлнэ

2. **Интернет ба Электрон шуудангаар дамжуулан хэлэлцүүлэг хийх:** Энержи Ресурс компанийн вэб сайт – www.energyresources.mn, одоогоор боловсруулагдаж байгаа бөгөөд 2008 он 11-р сарын 14 ажиллаж эхэлнэ, ЕСБХБ-ны вэб сайт - www.ebrd.com орон нутгийн мэдээллийн хэрэгслээр (доорхи нэр бүхий) зарлах, электрон шуудангаар санал солилцох хаяг: contact@energyresources.mn
3. **Хэвлэл ба мэдээллийн хэрэгслээр ярилцлага явуулах:** Улаанбаатар хотын сонинд тухайлбал өдөр тутмын сонин “Зууны мэдээ”, орон нутгийн сонин (10 өдөрт 1 дугаар гардаг) “Монголын говь”, болон долоо хоног тутмын англи хэл дээр хэвлэгддэг “UB Post” сонинд мэдээ өгөх, нийтлэл гаргах, хөдөө орон нутагт сонин хэвлэлийн түгээлт хангалтгүй байдаг учраас Ухаа худаг төслийн тухай мэдээллийг олон нийтийн радио буюу “Монголын үндэсний радио”, орон нутгийн “Говийн долгион” радиогоор дамжуулан нэвтрүүлэх, нээлттэй өдөрлөгийн зарыг сумын төвд байршуулна. Орон нутгийн харилцааны ажилтан Х. Мөнхбаттай үүрэн телефоноор харилцах боломжийг бүрдүүлнэ. Гар утасны дугаар: 9901-4082; электрон шуудангийн хаяг: munkhbat.kh@energyresources.mn
4. **Олон нийтийг дэмжих үйл ажиллагаа:** нийгмийн дэд бүтцийн чиглэлээр оруулж буй хөрөнгө оруулалтыг үргэлжлүүлэх бөгөөд тухайн хөрөнгө оруулалтын талаар орон нутгийн иргэдийн санал бодолыг сонсох, ярилцлага өрнүүлэх ажлыг ОНХА тогтмол зохион байгуулна.
5. **Орон нутгийн иргэд буюу малчидтай нүүр тулсан халуун яриа өрнүүлэх:** үүнийг 2008 оны 11, 12 дугаар саруудад зохион байгуулна. ОНХА болон уул уурхайн менежер зэрэг хүмүүс нөлөөллийн хүрээнд амьдрагч малчидтай биечлэн уулзах, нээлттэй өдөрлөгт урих зэрэг олон нийтийг идэвхижүүлэх арга хэмжээ авна.
6. **Байгаль орчны боловсрол, сургалтын арга хэмжээнүүд:** энэ чиглэлээр орон нутгийн төрийн байгууллагын албан тушаалтнуудыг татан оролцуулах, тараах материал, брошюр бэлтгэхээр төлөвлөж байна. Сургалт, танин мэдэхүйн материалуудыг Цогтцэций, Баян Овоо, Ханбогд сумын соёлын төвүүд, тухайн тохиолдолд сургуулиудаар дамжуулан олон нийтэд түгээх ажлын ОНХА удирдан зохион байгуулна.
7. **Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлангуудыг номын сан болон олон нийтийн үйлчилгээний газруудад байршуулан мэдээлэл түгээх:** алслагдмал бүс нутагт оршиж буй мэдээлэл харилцааны бүх сувгийг ашиглана. Эдгээрт сумын захиргаа, соёлын төвүүд, сургуулиуд, багийн захиргааны гэр зэрэг орно.

УХАА ХУДАГ ТӨСЛИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ АВАХ, САНАЛ ХҮСЭЛТ ӨГӨХ ЦЭГҮҮД



8. Сэтгүүл, хэвлэлд нийтлэл гаргах

Энэ хэлбэрээр мэдээлэл түгээх нь орон нутгийн сонирхогч талууд болон нөлөөллийн бүлгүүдтэй ажил хэрэгч холбоо үүсгэх үйл ажиллагааны эх үүсвэр байж болох юм. Энэ арга хэмжээний хүрээнд нээлттэй өдөрлөгүүдийг тодорхой хугацаатай зохион байгуулна. Үүнд ОНХА чиглүүлэгч үүрэгтэй оролцоно. Хавсралт 1-д энэхүү арга хэмжээний төлөвлөгөөг, хавсралт 2-т мэдээллийн түгээх уулзалтын хөтөлбөрийг үзүүлсэн.

Малын бэлчээр даган буурь сэлгэн амьдардаг малчдын дунд мэдээлэл түгээх нь зөвхөн нэг арга хэмжээгээр хязгаарлагдвал хангалтгүй үр дүнд хүрэх нь ойлгомжтой юм. Тиймээс Ухаа худаг төслийн зүгээс багийн засаг дарга нар, олон нийтийн бүлгүүд болон бусад хүмүүстэй мэдээлэл харилцааны бүх хэлбэрийг ашиглан холбоо тогтоож ажиллана. Үр дүнтэй хэлэлцүүлгийн явцад сонирхогч талууд санал хүсэлт гаргах механизмыг ашиглан өөрийн санаа бодлоо илэрхийлэх боломж бүрдэнэ.

5.1 Хөтөлбөр: Олон нийтийн хэлэлцүүлгийн ажлын төлөвлөгөө

i	Хийгдэх ажлууд	Хариуцах эзэн	Хугацаа
1.	ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ (Цогтцэций, Баяновоо, Ханбогд)		
1.1	Уулзалт, өдөрлөгийн хөтөлбөр боловсруулах	Ч. Баяржаргал, Зөвшөөрөл, лицензийн асуудал хариуцсан гүйцэтгэгч, утас# 9111-6655, e-mail: bayarjargal@mcs.mn	2008/11/03
1.2	Сум, багийн төв дээр уулзалтын зар тараах	Ч. Баяржаргал, Зөвшөөрөл, лицензийн асуудал хариуцсан гүйцэтгэгч, утас# 9111-6655, e-mail: bayarjargal@mcs.mn	2008/11/10
1.3	Ухаа худаг төслийн танилцуулгыг брошюр хэлбэрээр хэвлэн бэлтгэх;	Б.Баярмагнай, Засаг захиргаа эрхэлсэн захирал, утас #9910-0576, e-mail:bayarmagnai@energyresources.mn	2008/11/10
1.4	Ухаа худаг төслийн мэдээллийн самбарыг сумын төв дээр байрлуулж мэдээллийг тогтмол шинэчлэж байх	Х.Мөнхбат, Орон нутгийн харилцааны ажилтан, утас# 9901-4082	2008/11/15
1.5	Сонирхогчийн бүлгүүдтэй тогтмол харилцаа холбоотой байх зорилгоор санал хүсэлтийн хуудас боловсруулж тогтмол хэрэгжүүлэх;	З.Түмэннасан, Бичиг хэргийн ажилтан, ТМБ, Утас# 9977-2000, e-mail: tumennasan@mcs.mn	Тогтмол
1.6	Мэдээлэл түгээх хүнийг томилох	Х.Мөнхбат, Орон нутгийн харилцааны ажилтан, утас# 9901-4082	2008/11/15
1.7	Хүмүүс олноор цуглардаг байрлалыг тодруулах	Х.Мөнхбат, Орон нутгийн харилцааны ажилтан, утас# 9901-4082	2008/11/10
1.8	Сонирхогчийн бүлгүүдийг мэдээлэл солилцох процессд татан оролцуулах	Г.Тулга, Ш.Бат-Эрдэнэ, утас# 9911-5686, e-mail:tulga@mcs.mn, baterdene.sh@mcs.mn	2008/11/20
1.9	Дэвшигдсэн асуудлуудыг баримтжуулж, хариу өгөх, шийдвэрлэх, цахим хуудсанд мэдээлэл оруулах	З.Сугармаа, Захиргаа, хүний нөөцийн газрын дарга, утас# 8810-1111, e-mail:sugarmaa@energyresources.mn	15/XI-с эхлэн тогтмол

1.10	Үйл ажиллагааны хүрээнд холбоо амьдран суугч иргэдтэй холбоо тогтоож, хэлэлцүүлэг уулзалт зохион байгуулах	Ч. Баяржаргал, Зөвшөөрөл, лицензийн асуудал хариуцсан гүйцэтгэгч, утас# 9111-6655, e-mail: bayarjargal@mcs.mn	2008/11/15
1.11	Олон нийтийн хэлэлцүүлэг, уулзалтанд оролцогчдын сонирхолыг татах урамшууллын арга хэмжээ зохион байгуулах (алдартай дуучид, жүжигчдыг урих, хөнгөн зууш, сугалаа гм);	З.Сугармаа, Захиргаа, хүний нөөцийн газрын дарга, утас# 8810-1111, e-mail:sugarmaa@energyresources.mn	
1.12	Хөдөө орон нутагт олон нийтийн хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагуудын төлөөлөгчдийг хэлэлцүүлэг, уулзалтанд урьж оролцуулах	Х.Мөнхбат, Орон нутгийн харилцааны ажилтан, утас# 9901-4082	2008/11/15
2.	ИНТЕРНЕТ БА ЦАХИМ ШУУДАНГААР ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ХИЙХ		
2.1	Ухаа худаг төслийн үйл ажиллагааг мэдээлэх Вэб Сайт боловсруулах	З.Сугармаа, Захиргаа, хүний нөөцийн газрын дарга, утас# 8810-1111, e-mail:sugarmaa@energyresources.mn	2008/11/14
2.2	БОННБУ-ний тайлан, байгаль орчин ба нийгмийн асуудлуудыг тусгасан баримт материалыг цахим хуудсанд байршуулах	З.Сугармаа, Захиргаа, хүний нөөцийн газрын дарга, утас# 8810-1111, e-mail:sugarmaa@energyresources.mn	2008/11/10
2.3	Санал асуулгын цахим холбоо тогтоох, дэвшигдсэн санал асуулгуулуудыг судлаж, сонирхогчийн бүлгүүдийн санал хүсэл, зөвлөмжийн талаар тайлагнах үүрэг бүхий хүнийг томилон ажиллуулах, холбоо барих цахим шуудангийн хаягийг тодорхойлох;	З.Сугармаа, Захиргаа, хүний нөөцийн газрын дарга, утас# 8810-1111, e-mail:sugarmaa@energyresources.mn	2008/11/10
2.4	Монгол улсын Засгийн газар болон уул уурхай, байгаль орчин, нийгмийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын цахим хаягийг Вэб сайтэд байршуулах;	З.Сугармаа, Захиргаа, хүний нөөцийн газрын дарга, утас# 8810-1111, e-mail:sugarmaa@energyresources.mn	2008/11/10
2.5	Сумын төв дээр интернетэд холбогддог газруудтай (холбоо, сургууль гм) холбоо тогтоож, олон нийтийн хэлэлцүүлэг хийх талаар ярилцан тохиролцох;	Х.Мөнхбат, Орон нутгийн харилцааны ажилтан, утас# 9901-4082	15/XI-с эхлэн тогтмол

3.	ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ЯРИЛЦЛАГА (РАДИО, ТЕЛЕВИЗ, СОНИН)		
3.1	Орон нутгийн болон төвийн хэвлэл мэдээллийн сурвалжлагчдийг урьж Энержи Ресурс/ Ухаа худаг төслийн ажилчин, албан хаагч, сонирхолын бүлгүүдтэй ярилцлага хийх ажлыг зохион байгуулах	Б.Баярмагнай, Засаг захиргаа эрхэлсэн захирал, утас #9910-0576, e-mail:bayarmagnai@energyresources.mn	2008/11/15-20
3.2	Орон нутгийн радио, телевизээр сонирхолын бүлгийг оролцуулсан дугуй ширээний ярилцлага зохион байгуулах	Б.Баярмагнай, Засаг захиргаа эрхэлсэн захирал, утас #9910-0576, e-mail:bayarmagnai@energyresources.mn	2008/11/15 - 2009/01/31
3.3	Олон нийтэд мэдээлэл түгээх зорилгоор телевизийн олон үзэгчтэй програмыг тодруулж ашиглах	Б.Баярмагнай, Засаг захиргаа эрхэлсэн захирал, утас #9910-0576, e-mail:bayarmagnai@energyresources.mn	2008/11/15 - 2009/01/31
4.	ОЛОН НИЙТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА		
4.1	Орон нутгийн иргэдэд нээлттэй, шударга, үр ашигтай хэлэлцүүлэгт оролцох хүсэл эрмэлзлэлийг төрүүлэх хөтөлбөрүүд: <ul style="list-style-type: none"> ▪ Ядуурал бууруулах хөтөлбөр ▪ Эрүүл мэндийн хөтөлбөр ▪ Уламжлалт соёлын өвийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх ▪ Байгаль орчны хөтөлбөрүүд 	Б.Баярмагнай, Засаг захиргаа эрхэлсэн захирал, утас #9910-0576, e-mail:bayarmagnai@energyresources.mn	Нийгмийн хариуцлагатай бизнес төлөвлөгөөний дагуу энэ үйл ажиллагаа 2010 оны 1 дүгээр сар хүртэл үргэлжлэнэ
4.2	Ажиллах хүчний чадвар, боловсрол мэдлэг, бүтээмжийг дээшлүүлэх чиглэлээр дараахь ажлуудыг төлөвлөж байна. <ul style="list-style-type: none"> ▪ Хүн бүрд тэгш боломж олгох бодлого баримталж, мэргэжлээрээ өсч дэвжихэд дэмжлэг үзүүлнэ. ▪ Оюутны тэтгэлэгт хөтөлбөр ▪ Орон нутагт чиглэсэн хүний нөөцийн бодлого ▪ Хамтын ажиллагааны хөтөлбөр 	З.Сугармаа, Захиргаа, хүний нөөцийн газрын дарга, утас# 8810-1111, e-mail:sugarmaa@energyresources.mn	Нийгмийн хариуцлагатай бизнес төлөвлөгөөний дагуу энэ үйл ажиллагаа 2010 оны 1 дүгээр сар хүртэл үргэлжлэнэ

4.3	Нийгмийн дэд бүтцийн өргөтгөл шинэчлэлийн чиглэлээр төсөл хэрэгжүүлж сургуулийн багш, эмнэлгийн эмч мэргэжилтнүүдийн боловсрол мэдлэгийг дээшлүүлэх, техник тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэхэд зориулж тодорхой хэмжээний хуримтлал бүрдүүлэх	З.Сугармаа, Захиргаа, хүний нөөцийн газрын дарга, утас# 8810-1111, e-mail:sugarmaa@energyresources.mn	Нийгмийн хариуцлагатай бизнес төлөвлөгөөний дагуу энэ үйл ажиллагаа 2010 оны 1 дүгээр сар хүртэл үргэлжлэнэ
5.	НҮҮР ТУЛСАН ЯРИЛЦЛАГА		
5.1	Ярилцлагад оролцуулах боломжтой зорилтот бүлгийг (малчид, ажил хэрэгч хүмүүс, төрийн түшээд) тодруулах	Б.Баярмагнай, Засаг захиргаа эрхэлсэн захирал, утас #9910-0576, e-mail:bayarmagnai@energyresources.mn	2008/11/15–с тогтмол
5.2	Суурь судалгаанаас үндэслэн уурхайн үйл ажиллагааны хүрээнд хамрагдсан байж болзошгүй зорилтот бүлгүүдийг тодорхойлж, тэд нараас гарч болзошгүй асуулгад хариулах стратегийг боловсруулах	Ш. Байгалмаа, Ц. Баасандорж, Х. Мөнхбат, ЭР + ТМБ	2008/11/10
5.3	Ухаа худаг төслөөс орон нутгийн иргэдтэй харилцан ашигтай хамтран ажиллах механизмыг бүрдүүлэх	Ш. Байгалмаа, Ц. Баасандорж, Х. Мөнхбат, ЭР + ТМБ	тогтмол
6.	БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ		
6.1	Зорилтот бүлгүүдэд (оюутан, малчид гм) зориулан Хариуцлагатай уул уурхай, Байгаль орчин, ХХААЭА-н чиглэлээр сар тутмын танин мэдэхүйн илтгэл тавих	Б. Батбагана, Байгаль орчны менежер, утас#9908-4443, e-mail:Batbagana@energyresources.mn	Эхлэх: 2008/11/09, сар бүр
6.2	Ухаа худаг төслийн БО, ХХААЭА-н шилдэг менежментийг орон нутгийн иргэдэд тайлбарлан таниулж, хүлээн зөвшөөрүүлэх	Х.Батболд, З.Сугармаа + ТМБ	15/XI-с эхлэн тогтмол
7	ТАЙЛАНГИЙН МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ		
7.1	Орон нутгийн иргэд, зорилтот бүлгүүдэд тайлан	З.Сугармаа, Захиргаа, хүний нөөцийн	Сар бүр

	мэдээллийг хүргүүлж (сум багийн номын санд байршуулах) тэдний санал бодлыг хүлээн авах ажлыг зохион байгуулах	газрын дарга, утас# 8810-1111, e-mail:sugarmaa@energyresources.mn	
7.2	БОННБУ-ний тайлангуудыг олон нийтэд хүртээх бодлогыг тогтмол баримтлан, тэдний саналыг хүлээн авах	З.Сугармаа, Захиргаа, хүний нөөцийн газрын дарга, утас# 8810-1111, e-mail:sugarmaa@energyresources.mn	Сар бүрийн мониторинг
7.3	Тайлан байршуулсан газарт олон нийтийн санал хүсэлтийг хүлээн авах санал хүсэлтийн хуудас, санал хүсэлт хийх хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр зэрэг мэдээлэл солилцооны хэрэгсэлийг бий болгох	З.Сугармаа, Захиргаа, хүний нөөцийн газрын дарга, утас# 8810-1111, e-mail:sugarmaa@energyresources.mn	Сар бүрийн мониторинг
8	СЭТГҮҮЛД НИЙТЛЭЛ ӨГӨХ		
8.1	Орон нутгийн сэтгүүлд төслийн тухай мэдээлэл нийтлүүлэх ажлыг идэвхитэй хэлбэрээр явуулах	З.Сугармаа, Захиргаа, хүний нөөцийн газрын дарга, утас# 8810-1111, e-mail:sugarmaa@energyresources.mn	Тодорхой хугацааны давтамжтай
8.2	Байгаль орчин бай БОННБУ-ний талаар олон улсын сэтгүүлд мэдээлэл нийтлүүлэх	Б.Баярмагнай, Засаг захиргаа эрхэлсэн захирал, утас #9910-0576, e-mail:bayarmagnai@energyresources.mn	Тодорхой хугацааны давтамжтай

6.0 Санал хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх арга зам

Санал хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх ажлын мөн чанар нь орон нутгийн иргэдээс санал хүсэлт хүлээн авч, зохих шийдвэр гарган, хүсэлт гаргагчид эргүүлж мэдээлэхэд оршино. Санал хүсэлтийг хавсралт 4-т тусгасан процедурын дагуу хүлээн авч ямар нэгэн хүндрэл гаргалгүйгээр хянаж, шийдвэрлэнэ.

Ялангуяа, Ухаа худаг төслийн хувьд санал хүсэлтийг шийдвэрлэн хариу өгөх хугацаа нь 30 хоног байх бөгөөд шаардлага гарсан тохиолдолд тухайн нөхцөл байдал дээр үндэслэн богино хугацаанд яаралтай шийдвэр гаргаж болно. Ухаа худаг төслийн зүгээс иргэдээс ирж буй санал хүсэлтийн нууц байдлыг хадгалж, тохиолдол бүрийг ялгаварлан гадуурхалгүйгээр хянан үзэж шийдвэрлэх зарчим баримтлана.

Бүх санал хүсэлт болон тэдгээрийн тайланг санал хүсэлтийн дэвтэрт бүртгэнэ. Ерөнхий тайланг (арилжааны болон хэт хувийн чанартай мэдээллийг хасна) жилд 2 удаа гаргана. Энэхүү тайланг олон нийтэд нээлттэй хэлбэрээр хүргэж нийгмийн хариуцлагатай, ил тод үйл ажиллагаа явуулдаг компани гэдгээ илэрхийлнэ.

Санал хүсэлт хүлээн авах үйл ажиллагааг Олон нийтийн харилцааны ажилтан Х.Мөнхбат (утас# 9901-4082) удирдан зохион байгуулах бөгөөд Захиргаа, хүний нөөцийн газрын дарга З. Сугармаа, (утас# 8810-1111, e-mail: sugarmaa@energyresources.mn) хяналт хийнэ.

Аман болон бичгийн хэлбэрээр ирж буй санал хүсэлтийг Санал хүсэлтийн хуудас (хавсралт3) бөглүүлэх хэлбэрээр эсвэл санал гомдлын дэвтэрт бүртгэх замаар хүлээж авна.

Санал хүсэлтийн хуудсанд дараахь мэдээллийг оруулна. Үүнд:

- Санал хүсэлт хүлээн авсан огноо;
- Санал хүсэлт гаргагчийн мэдээлэл;
- Санал хүсэлт гаргагчид хариу илгээсэн мэдээлэл (боломжтой бол);
- Асуудал шийдсэн огноо
- Санал хүсэлт гаргагчид хариу илгээсэн огноо.

Санал хүсэлтийн хуудсуудыг санал хүсэлтийн давамж, давамгайлж байгаа сэдвийн дүн шинжилгээ хийхэд ашиглана. Санал хүсэлтийн дэвтэрийг санал хүсэлтийн мэдээллийг бүртгэн тэмдэглэхэд хэрэглэнэ.

Санал хүсэлтийг бүртгэхдээ дараахь 4 хэсэгт хуваана. Үүнд:

Хэсэг А: Санал хүсэлт гаргагчийн мэдээлэл, санал хүсэлтийн тоо (санал хүсэлтийн хуудаснаас), хариу шийдвэр гаргах арга замууд.

Хэсэг В: Санал хүсэлтийн мэдээллийг нэгтгэн бүртгэх хэсэг.

Хэсэг С: Яаралтай шийдвэр гаргах, асуудлыг шийдвэрлэх талаар урт хугацааны үйл ажиллагаа явуулах (шаардлагатай бол).

Хэсэг D: Гаргасан шийдвэр хэрхэн баталгаажсан тухай.

7.0. Тайлагнах

Энержи Ресурс компани нь БОННБҮ-ний баримт бичгийг хэвлүүлж, хэлэлцүүлэгийн үйл ажиллагааны явцад үүссэн асуудлуудыг нэгтгэн компанийн Вэб сайтад байршуулж, санал хүсэлт авах нөхцлийг бүрдүүлнэ. Тухайн баримт бичгийн хувийг сумын соёлын төв, төслийн мэдээллийн цэг дээр тогтмол байлгана.

Төсөл хэрэгжих нийт хугацааны туршид Энержи Ресурс компанийн зүгээс ОНХТ-д тусгаснаар сонирхогч талуудтай мэдээлэл солилцох харилцааны боломжит бүх сувгийг ашиглах бөгөөд ОНХА эдгээр сувгуудыг үргэлж нээлттэй байлгах хариуцлага хүлээнэ.

Санал хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн зэрэгцээ Энержи Ресурс компаниас сонирхогч талуудад төслийн талаарх шинэлэг мэдээллийг тогтмол хүргэж байна. Жишээлбэл, төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөрт өөрчлөлт орох зэрэг мэдээг хүргэж болно. Энержи Ресурс компани өөрийн вэб сайтад төслийн явцын шинэ мэдээллийг тогтмол байршуулж байх бөгөөд ОНХА-р дамжуулан сонирхогч талууд тухайн мэдээллийг түгээнэ. Үүнд нээлттэй өдөрлөг, сумын захиргаан дээр байршуулсан мэдээллийн самбаруудыг ашиглана.

Энержи Ресурс компанийн зүгээс барилга угсралтын ажил болон бусад үйл ажиллагааны явцад компанийн байгаль орчин, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, нийгмийн бодлого төлөвлөлтийн менежмент дээр үндэслэн байгаль орчин, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны жилийн тайлан гаргана. Мөн энэхүү тайланг Вэб сайт болон сумын мэдээллийн төвүүдэд байрлуулна.

7.1 Мэдээлэл авах, холбоо барих хаягууд

Мэдээлэл түгээх цэгүүд

(Тайлбар: Хөдөө орон нутагт тодорхой хаяг байдаггүй учраас олны дунд түгээмэл тархсан нэрийг хаяг хэлбэрээр ашигладаг)

1. Цогтцэций, Баян Овоо, Ханбогд сумын Соёлын төвүүд
2. Цогтцэций, Баян Овоо, Ханбогд сумын Сургуулиуд
3. Уурхайн кемпийн нээлттэй мэдээллийн гэр – төслийн мэдээллийн тараах материал, брошюрийг олон нийтэд түгээх, тэдний санал хүсэлтийг хүлээн авах зэрэг үйл ажиллагаа явуулна
4. Олон нийтийн харилцааны ажилтан, Цогтцэций суманд амьдардаг, харилцах утас (9901-4082), шаардлагатай бол Өмнөговь аймгын бусад сумуудаар орж сонирхогч талууд уулзах боломжтой
5. Улаанбаатар хотын төв офис

Энержи Ресурс компанийн төв офис

Албан хаяг: Улаанбаатар хотын

Сүхбаатар дүүргийн 1-р хороо,
Сөүлийн гудамж, Од Плаза, 2-р давхар

Бизнес хаяг: Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүргийн 1-р хороо,
Жуулчны гудамж, Макс Цамхаг,
8-р давхар

Утас.: 322279, Факс.: 330290,
Contact@energyresources.mn

Х.Мөнхбат, Олон нийтийн харилцааны ажилтан, утас# 9901-4082

Б. Баярмагнай, Засаг захиргаа эрхэлсэн захирал, утас#9910-0576,
bayarmagnai@energyresources.mn

ЕСБХБанк Улаанбаатар офис


Монгол улс,
Улаанбаатар - 210644
Сөүлийн гудамж – 4А
MCS Плаза
3-р давхар

Утас: + 976 11 317 974/298
Факс: + 976 11 315 844
Захирал: John Chomel-Doe

ЕСБХБанк Лондон төвтэй Бизнес мэдээллийн төв

One Exchange Square
London EC2A 2JN, UK
Tel: +44 20 7338 6747
Fax: +44 20 7338 6155
Website address. <http://www.ebrd.com/projects/eias/index.htm>

Байршлын зураг:



8.0 Эх сурвалжууд

ЕСБХБанкны Гүйцэтгэлийн Шаардлагын баримт бичиг (2008)

Монгол улсын хуулиудын эмхтгэл Байгаль орчин (1997), Байгаль орчны яам, Монгол улс, Орбис ХХК-ний хэвлэл

БОННБҮ – Ухаа худаг уурхай . Sustainability, 2008.

БОННБҮ – Ухаа худаг Гашуун сухайт чиглэлийн зам сайжруулах төсөл, Sustainability, 2008.

Хавсралт 1: Нээлттэй өдөрлөгийн хөтөлбөр

Зорилго:	Орон нутгийн иргэдэд төслийн мэдээлэл түгээх ажлын хүрээнд: <ul style="list-style-type: none">(i) Эерэг уур амьгал, итгэл үнэмшил бий болгох(ii) Харилцааны нээлттэй, таатай орчин бүрдүүлж орон нутгийн иргэдийг санаа бодолыг сонсож, мэдээлэл солилцох үйл ажиллагаа явуулна.
Анхаарал төвлрүүлэх асуудлууд:	<ul style="list-style-type: none">(i) Ухаа худаг төслийн товч танилцуулга(ii) Байгаль орчинд ээлтэй, өндөр технологи дамжуулал(iii) Хэмнэлттэй, шилдэг арга барил(iv) Нийгмийн хариуцлага, сайн хөрш
Зорилтот бүлгүүд:	Анхдагч: Орон нутгийн малчид Хоёрдогч: Орон нутгийн төрийн ба төрийн бус байгууллагууд болон бусад
Сонирхогч талууд:	Энержи Ресурс компани, сумын эрх бүхий байгууллагууд ба төрийн бус байгууллагууд
Мэдээлэл түгээх аргачлал:	<ul style="list-style-type: none">(i) Нүүр тулсан ярилцлага(ii) Сурталчилгааны материал, брошюр тараах(iii) Мэдээллийн самбар(iv) Илтгэл(v) Үдэшлэг зохион байгуулах
Хэвлэл мэдээлэлийн хэрэгсэл:	Орон нутгийн сонинд мэдээ нийтлүүлэх, орон нутагийн телевизэд ярилцлага өгөх, Радио програм, видео, фото зургийн баримтжуулалт

Хавсралт 2: Уул уурхайн танин мэдэхүйн мэдээллийн үйл ажиллагааны хөтөлбөр – 2008/11/10

Хугацаа: 11/10/2008

Байршил: Өмнөговь аймаг, Ухаа худаг кемп

	Илтгэлүүд	Хугацаа	Хариуцах эзэн	
1	Ухаа худаг нүүрсний уурхайн хэтийн төлөв (уурхай, дэд бүтэц, нийгмийн хөгжил, олон нийтийн харилцаа гм)	15 ' илтгэл 10' асуулт хариулт	Г. Батцэнгэл	Гүйцэтгэх захирал, Энержи Ресурс ХХК
2	Уурхайн үйл ажиллагаа	15 ' илтгэл 10' асуулт хариулт	Д. Чинбат	Уул уурхай, геологийн газрын дарга, Энержи Ресурс ХХК
3	Хариуцлагатай уул уурхай, БО, ХХАА, Ажиллагсдын хариуцлага	15 ' илтгэл 10' асуулт хариулт	Ш. Байгалмаа	Дэд бүтэц, ХХААЭХ, БО-ны газрын дарга, Энержи Ресурс ХХК
4	Байгаль орчин ба нөхөн сэргээлт	15 ' илтгэл 10' асуулт хариулт	Б. Батбагана	Байгаль орчны менежер, Энержи Ресурс ХХК
5	Ажил олгох тэгш боломж, орон нутгийн ажиллах хүч	15 ' илтгэл 10' асуулт хариулт	З.Сугармаа	Захиргаа, хүний нөөц, нийгмийн харилцааны газрын дарга, Энержи Ресурс ХХК
Завсарлага				
6	Ухаа худаг кемпийн үйл ажиллагаа, Хэтийн зорилтууд	15 ' илтгэл 10' асуулт хариулт	Н. Батболд	Кемп менежер, Энержи Ресурс ХХК
7	Кемпийн үйлчилгээ, Оффиснет ХХК, танилцууллага, үйл ажиллагааны зорилго, ажил олгох бодлого	15 ' илтгэл 10' асуулт хариулт	Алтанцэцэг	Гүйцэтгэх захирал, Оффиснет ХХК
8	Үйлчилгээний шаардлага, стандартууд	15 ' илтгэл 10' асуулт хариулт	Уянга	Офис менежер, Оффиснет ХХК
9	Эрүүл мэнд, эрүүл ахуйн сургалт	15 ' илтгэл 10' асуулт хариулт	Оюунсүрэн	Эрүүл ахуйч, Энержи Ресурс ХХК
10	Нээлттэй хэлэлцүүлэг	25 '	Бүх оролцогчид хамрагдана	

Нийт цаг:

Зцаг

Хавсралт 3: САНАЛ ХҮСЭЛТИЙН ХУУДАС

1. ТА ГАРГАЦТАЙ ТОД БИЧНЭ ҮҮ.
2. ХУУДСАНД БАЙГАА МЭДЭЭЛЛИЙГ БҮРЭН БӨГЛӨНӨ ҮҮ.
3. ГАРЫН ҮСГЭЭР БАТАЛГААЖУУЛНА ҮҮ.

◆САНАЛ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Таны нэр (овог/нэр): _____

Гэрийн утас: _____ Ажлын утас: _____ Гар утас: _____

Хаяг: _____

Энэ хаяг нь: Гэрийн Ажлын Сургуулийн Байгууллагын аль нь болохыг
тэмдэглэнэ үү.

◆ТАНЫ САНАЛ ХҮСЭЛТ:

(энэхүү хуудасны ард дэлгэрүүлэн бичиж болох бөгөөд шаардлагатай баримтыг хавсаргаж болно)

◆ЭНЭ АСУУДЛЫН МӨРӨӨР ЯМАР АРГА ХЭМЖЭЭГ АВЧ БОЛОХ ТАЛААР ТАНЫ САНАЛ?

/Миний өгсөн дээрх мэдээлэл нь үнэн зөв болно./

Гарын үсэг: _____

Огноо: _____

Буцах хаяг: Ухаа Худаг Кэмп, Цогтцэций Сум, Өмнөговь аймаг

Энержи Ресурс Улаанбаатар оффис, Од Плаза, Сөүлийн гудамж, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо

Хүлээн авсан: _____

Огноо: _____

Хавсралт 4: Санал хүсэлт барагдуулах процесс

